



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтын 1-ээс 4-т заасан 4 хуулийн этгээдэд “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай, 5-аас 6-д заасан 2 хуулийн этгээдэд “Шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай, 7-д заасан 1 хуулийн этгээдэд “Интернэтийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай тус тус олгосугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдүүдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн
35 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Файвер оптик констракшин ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл. - Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар - Цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсралт суурилуулалт, засвар	2021.05.14	2024.05.14
2	Эйч Би Ди Эм ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл. - Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар - Цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсралт суурилуулалт, засвар	2021.05.14	2024.05.14
3	ХД Прогресс ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл. - Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар	2021.05.14	2024.05.14
4	Сэрхийн туяа ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл. - Цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсралт суурилуулалт, засвар	2021.05.14	2024.05.14

5	Эрчист гүрэн ХХК	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл	2021.05.14	2024.05.14
6	Хөүм кабс ХХК	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл	2021.05.14	2024.05.14
7	Ай си ай систем монголиа ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Интернэтийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл	2021.05.14	2031.05.14

----- оОо -----